

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30

|   |                  |
|---|------------------|
| <b>Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ</b><br><b>Гоёлын болон биеийн шивээсний үйлчилгээ</b><br><b>Ерөнхий шаардлага</b> | <b>MNS :2021</b> |
| <b>Service for costumers</b><br><b>Cosmetic and body tattoo services</b><br><b>General requirements</b>               |                  |

Стандарчлал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2020 оны ...сарын ...ны өдрийн .....-р тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 20.... оны .... сарын .... ны өдрөөс эхлэн хүчинтэй

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. ЗОРИЛГО

Энэхүү стандартыг бий болгосноор үйл ажиллагаа явуулж байгаа цэг салбары нэг цэгцэнд оруулж, үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлж ХАБЭА-г ханган ажиллах, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тэдний эрх ашгийг хамгаалсан үйлчилгээ болгон хөгжүүлэх, мэргэжилтүүдийн мэргэжлийн боловсрол ур чадварыг дээшлүүлэх, зэрэг олгох, шинэ техник технологийг нэвтрүүлж олон улсын түвшинд хүргэхэд оршино.

### 2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ стандарт нь шивээсний үйлчилгээг төлбөртэй ба төлбөргүйгээр эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

### 3. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

3.1 Шивээсний үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага иргэд хамаарна.

3.2 Шивээсний үйлчилгээ эрхлэхээр зорьж буй этгээд стандарт шаардлагыг төлөвлөлтөнд тусган, цаашид мөрдлөг болговол зохино.

3.3 Шивээсний үйлчилгээ үзүүлэгч этгээд нь нэгдсэн зохион байгуулалт бүхий тогтолцоо бүртгэлтэй байж, тэдгээрт зэрэглэл олгох шаардлага тавихад энэхүү стандартыг үндэслэл болгоно.

3.4 Шивээсний үйлчилгээг суурин бус явуулын үйлчилгээ үзүүлэхэд энэхүү стандартаар тогтоосон холбогдох заалтуудыг хангана.

### 4. НОРМАТИВ ИШЛЭЛ

Дараах стандартын үзүүлэлт, шаардлагаас эшлэл болгон хэргэлсэн. Эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн хэвлэлийг \ түүний өөрчлөлтүүдийг оруулаад\ хэрэглэнэ.

Үүнд:

- MNS 4968, Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага,
- MNS 4990, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүд ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага,
- MNS 6767, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөгдөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага.
- MNS 4244 Хөдөлмөр хамгаалалын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
- MNS 5390, цахилгааны галын аюулгүй байдал. Ерөхий шаардлага
- MNS 49318 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага
- MNS 6423 ~2019, Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага

- MNS 5078: 2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага
- SO17442, ISO4217, ISO9002 олон улсын стандарт мөрдөх
- ISO 13485 Шивээс арилгах олон улсын стандарт
- ISO 2012; 148:820-3 хэрэглэгдэх материал багаж

## 5. НЭР, ТОМЪЁО ТОДОРХОЙЛОЛТ

- 5.1 Гоёлын шивээсчин \хагас болон байнгын тогтоцтой будгаар будагч \ Permanent make up artist хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдаж мэргэжлийн гэрчилгээ, үнэмлэх, дипломтой мэргэжилтэнг хэлнэ.
- 5.2 Биеийн шивээсчин \ хагас болон байнгын тогтоцтой будгаар будагч\ body tattoo artist хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдаж мэргэжлийн гэрчилгээ, үнэмлэх, дипломтой мэргэжилтэнг хэлнэ.
- 5.3 Хагас тогтоцтой будаг гэдэг нь тодорхой хугацааны дараа арилах будгийг хэлнэ.
- 5.4 Байнгын тогтоцтой будаг гэдэг нь удаан хугацааны тогтоцтой болон насан туршийн үлдэцтэй будаг
- 5.5 Шивээсний үйлчилгээ үзүүлэх газар :Үйлчлүүлэгчийн хүсэлт, захиалгын үндсэн дээр хагас болон байнгын тогтоцтой будгаар хөмсөг, зовхи болон **уруулыг хэлбэржүүлэн өнгийг сэргээх, шивэх болон биенд зураглалтай шивээс** хийх үйлчилгээний газрыг хэлнэ.
- 5.6 Арьс : Хүний биеийг хучиж байдаг хамгийн том эрхтэн юм.
- 5.7 Шивээс

А. Гоёлын гоо сайхны шивээс гэдэг нь хэрэглэгчийг илүү үзэсгэлэнтэй болгож нүүр будалтыг удаан хугацаанд хадгалахад нь тусалж хагас болон байнгын тогтоцтой будгаар хөмсөг, нүд, уруулын хүрээ, болон уруулын өнгийг сэргээх, хүссэн үр дүндээ хүрэхийн тулд арьсны өнгөн давхрагын доод хэсэгт **болон арьсны жинхэнэ давхрага хоёрын завсарт** будагч бодис тогтоохыг хэлнэ. **Тайлбар; Шивээсний будгийн тогтолтын хугацаа нь 6 сараас 3 жил хадаглагдах бөгөөд яваандаа өнгө нь аажмаар бүдгэрч арилна.**

### **Б. Биенд зураглалтай шивээс хийх:**

Биеийн шивээс нь хэрэглэгчийн хүсэл сонирхолын дагуу хагас болон байнгын тогтоцтой будгаар хүний биеийн өнгийг өөрчлөх, зураглал хийх арга бөгөөд мэргэжлийн будаг ашиглан хүссэн үр дүндээ хүрэхийн тулд арьсны өнгөн давхрагын доод хэсэгт болон арьсны жинхэнэ давхрагад будагч бодис тогтоохыг хэлнэ. Энэ нь яваандаа өнгө нь аажмаар бүдгэрэх боловч тогтоц удаан учир биеийн шивээс гэнэ. Персинг **чимэглэл**

### 5.8 Шивээс арилгах:

Хэрэглэгчийн шаардлага хангаагүй шивээсийг мэргэжлийн бүтээгдэхүүн болон тоног төхөөрөмжөөр арилгах хэлнэ.

## 6. ШИВЭЭСНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГАЗРЫН ЗЭРЭГЛЭЛ, АНГИЛАЛ

6.1 Аж ахуй нэгж байгуулагад энэхүү стандартаар тогтоосон шаардлага, үйлчилгээний чанар хүртээмж, тоног төхөөрөмж, тохижилт, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлсноор тодорхойлж болно.

Үүнд:

|                     |  |
|---------------------|--|
| Зэрэглэл            | Нэршил                                 |
| Дээд зэрэглэл       | Шивээсний дагнасан үйлчилгээтэй        |
| Нэгдүгээр зэрэглэл  | Үс гоо сайхан хумс заслын үйлчилгээтэй |
| Хоёрдугаар зэрэглэл | Үс, хумс болон гоо заслын үйлчилгээтэй |

Тайлбар; Нэг, хоёрдугаар зэрэглэлийн үйлчилгээний газрын зэрэглэлийн ялгаа нь “А” хавсралтад тусгагдсан шаардлагаар тогтодоно.

6.2 Шивээсний үйлчилгээ үзүүлэх газрын зэрэглэлийг: зэрэглэлд тавих ерөнхий шаардлага, А хавсралтанд тусгагдсан шаардлагуудыг хангаж байгаа эсэх талаар тогтоосон журмын дагуу холбогдох төрийн байгууллага болон ХНХЯ, Мэргэлийн Боловсрол Сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн даргын 2020 оны 9 сарын 29 ны өдрийн мэргэжлийн зөвлөл байгуулах тухай А\117 тоот тушаалаар батлагдсан үсчин, гоо засалч, хумс засалчдын мэргэжлийн зөвлөл тогтоож зэрэглэл тогтоосон гэрчилгээ батламжийг олгоно

6.3 Шивээсний үйлчилгээнд дараах төрлийг хамруулна.

А. Хагас болон байнгын будагаар гоёлын шивээс хийх

- Хөмсөг хэлбэржүүлэн будах
- Нүдний зовхинд хүрээ хийх
- Уруулыг хэлбэржүүлэн хүрээ хийх
- Уруулын өнгө сэргээх
- Мэнгэ, сэвхи шивэх
- Үсний халцархай болон шингэрэлтийг нөхөн сэргээх
- Хөхний толгойны өнгө сэргээх
- Шивээс арилгах

Б. Хагас болон байнгын будгаар биеийн шивээс хийх

- Бүтэн биеийн зураглалтай шивээс хийх
- Хэсэгчилсэн зураглалтай шивээс хийх
- **шүрших аргаар нөхөн сэргээх шивээс хийх \тамгалах\**
- Хөхний толгойны өнгө сэргээх

## 7. ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1 Монгол улсад бүртгэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллага шивээсний үйлчилгээ эрхэлнэ.

7.2 Шивээсний үйлчилгээ эрхлэх хүний нөөц нь эрх зүйн чадамжтай болохыг нотолсон мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, дипломтой байна.

7.3 Үйлчилгээний газарт эрүүл ахуй ариун цэврийн шаардлага хангаагүй газарт үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

7.4 Шивээсний үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл мэргэжлийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлнэ.

7.5 Шивээсний үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа бүтээгдэхүүн нь лабораторын шинжилгээгээр баталгаажсан мэргэжлийн бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.

7.6 Үйлчилгээ үзүүлэгч этгээд нь өөрийн эзэмшил өмч биш газарт үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн эзэмшигч этгээдтэй түрээсийн, хамтын ажиллагааны, хөлсөөр ажиллах зэрэг хууль эрхийн актад нийцсэн тохирох гэрээг бичгээр байгуулсан байна.

7.7 Үйлчлүүлэгч арьсны ямар нэгэн өвчлөлтэй бол үйлчилгээ хийхийг хориглоно.\ эмнэлгийн байгууллагад хандах зөвлөмж өгнө\

7.8 Үйлчилгээнд хэрэглэгдэх бүтээгдэхүүний танилцуулагыг үйлчилгээ эхлэхээс өмнө урьдчилан танилцуулж, хэрэглэх эсэх талаар саналыг урьдчилан авах ба хэрэв нэг удаагийн багаж, хэрэгсэл хэрэглэх тохиолдолд сав баглаа боодлын битүүмжилсэн байдлыг үзүүлж танилцуулдаг байна.

7.9 Үйлчлүүлэгчийн хүсэлтээр захиалга ба урьдчилгаа төлбөр хийгдсэн, хэрэглэсэн бүтээгдэхүүн гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төрөл огноо, хугацаа зэргийг тусгасан баталгааны буюу төлбөрийн баримт олгоно.

7.10 Шивээсний үйлчилгээг гоо засал, үсчин, хумс заслын үйлчилгээтэй хамт агаарын нэг урсгалтай танхимд явуулахыг хориглоно.

7.11 Үйлчилгээг эрүүл ахуйн холбогдох стандартын шаардлага хангасан үйлчилгээний дотоод журам, технологийн зааварт нийцүүлэн явуулна.

## **8. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА**

8.1 Шивээсний үйлчилгээ үзүүлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын шаардлага хангасан орчинд үйл ажиллагаа явуулна

8.2 Цэвэр бохир ус, дулааны төвлөрсөн ба төвлөрсөн бус системд холбогдсон, халуун хүйтэн устай байх ба ундны усны холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.

8.3 Гэрэлтүүлгийн хэмжээ нь “MNS 6767:2019 ХАБЭА. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөгдөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангаж ажиллана

8.4 Шивээсний үйлчилгээг дараах байршилд байгуулах буюу үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

а. Барилга байгууламжийн зоорийн давхар буюу агуулахад

б. Байгалийн гэрэлтүүлэг тусахгүй, агаарын сэлгэх урсгалгүй байгууламжид

в. Үйлчилгээг орон сууц, хүнсний дэлгүүр, нийтийн хоолны байгуулагатай шууд холбогдох газар

8.5 Үйлчилгээний зориулалттай барилга байгууламжинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангахаар төлөвлөгдсөн, тэргэнцэрийн зориулалтын зам тохижилттой байна.

8.6 Үйлчилгээний төвийн шивээсний танхим нь дуу чимээнээс тусгаарлагдсан эрүүл ахуйн шаардлага хангасан ханаар тусгаарлагдсан байна.

8.7 Үйлчилгээний газар MNS 4244, MNS 5390, стандартын шаардлагыг хангасан байна.

8.8 Шивээсний үйлчилгээний байгууллагага нь норматив шаардлагыг хангасан, зориулалтын буюу үйлчилгээний шаардлага хангахуйц байр, өрөө тасалгаанд үйл ажиллагаагаа явуулна

8.9 Үйлчилгээний байгууллага нь хаяг, цагийн хуваарийг үйлчлүүлэгчид харагдахуйц газарт байршуулсан байна.

8.10 Ажлын байрны агаар сэлгэлт хангалтгүй байгаагаас үйлчилгээний танхим нь агаар сэлгэх механик төхөөрөмжийг нэмэлтээр суурилуулах ба хүчин чадлыг тохируулах боломжтой байна.

8.11 Үйлчилгээний газрынхаа орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцна

8.12 Дүрс бичлэгийн зориулалтын теле камерийн системээр тоноглогдсон байна

8.13 Шивээсний үйлчилгээний газар нь “А” хавсралтанд заасан үзүүлэлт шаардлагыг хангасан байна.

8.14 Үйлчилгээний газрын хогийг битүү саванд хийж тодорхой хугацаанд зайлуулна. \ Эрүүл мэндийн сайдын баталсан Эмнэлгийн хог хаягдал устгах тухай журам”-н дагуу”

8.15 Үйлчлүүлэгчид зориулсан кофе, цай, ус ундаа, болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн худалдах борлуулах өрөө буюу хэсэгтэй байж болно.

8.16 Үйлчилгээний газрын зэрэглэл, ажилтны мэдээллийг үйлчлүүлэгчид харагдахуйц газарт байршуулна.

8.17 Мэргэжлийн байгууллагаас баталсан холбогдох технологийн заавар, дотоод журам, үйлчилгээний үнийн тариф зэргийг үйлчлүүлэгч танилцаж болох ил газар байршуулсан байна.

Тэмдэглэл; Үйлчлүүлэгчийн үйлчилгээний талаар сэтгэл ханамж, санал гомдол авах, эсвэл хандаж болох байгууллагын интернет хаяг, утасны дугаар зэргийг нэмэлтээр заалт болгон оруулсан байна.

8.18 Үйлчилгээний газар нь ажилчдын хувцас солих, угаалгын, ариун цэврийн, амралтын тусдаа өрөө буюу хэсэгтэй байна.

- 8.19 Үйлчилгээний газрын талбай хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна.
- а. Нэг шивээсчин 4м.кв-с багагүй ажлын талбайтай байна.
  - б. Шивээсний орны хоорондын зай 1метрээс багагүй байна.
  - в. Үйлчилгээний ор нь хөдөлгөөнд саад учруулахгүйгээр байршсан байна.
- 8.20 Үйлчлүүлэгчийн хүлээлгийн сандал, буйдантай байх ба ширээтэй байж болно.
- 8.21 Үйлчлүүлэгчийн гадуур хувцас өлгөх өлгүүртэй байна.
- 8.22 Шивээсний болон гоо заслын мэргэжлийн бүтээгдэхүүн борлуулах хорготой байж болно.
- 8.23 Үйлчилгээний байгууллага нь анхны тусламжийн эмийн сантай байна.
- 8.24 Үйлчилгээний газрын дотоод журам нь хууль эрх зүйн акт болон энэхүү стандартад нийцсэн байна.
- 8.25 Гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээнд бүртгэл, захиалгын хуудас, төлбөрийн тасалбар, тооцооны хуудас хэрэглэнэ.
- 8.26 Шивээсний үйлчилгээний байгууллагад энэхүү стандартын 'В' хавсралтанд заасан багаж, тоног төхөөрөмж заавал байна.

## **9. ӨРӨӨ ТАСАЛГАА, БАГАЖ ХЭРЭГСЛТЙН УГААЛГА, ХАЛДВАРГҮЙТГЭЛ**

- 9.1 Үйлчилгээний өрөө тасалгааны ариутгал, хортон шавьжийн устгалыг эрүүл ахуйн норм, дүрэм, зөвлөмжийн мэргэжлийн байгууллагаар тухай бүр, тодорхой давтамжтайгаар хийлгэнэ.
- 9.2 Норм, дүрэм, журам, зөвлөмжийн дагуу шаардлагад нийцсэн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол, тухай бүр хийнэ.
- 9.3 Шивээсний үйлчилгээнд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг, ариутгах зориулалтын тоног төхөөрөмж, бодистой байх ба технологийн заавар аргачлалын дагуу хэрэглэнэ.
- 9.4 Үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа багаж, хэрэгслийг дор дурдсны дагуу угааж ариутгасан байх ба мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар аргачлалыг үйл ажиллагаандаа хэвшүүлж, халдварт өвчин дамжуулах эрсдэлээс сэргийлнэ.
- 9.5 Үйлчилгээнд нэг удаагийн амны хаалт, бээлий малгай, нөмрөг, зэргийг хэрэглэж болох ба **ариун материалуудын** ариун цэврийн чанарыг алдагдуулахгүй нөхцөлд хадгалж, зориулалтын дагуу хэрэглэнэ.
- 9.6 Үйлчилгээнд хэрэглэгдэж буй багаж хэрэгслийг үйлчлүүлэгч бүрийн дараа халдваргүйжүүлнэ.
- 9.7 Шивээсэнд хэрэглэсэн багаж хэрэгслийг цэвэрлэж, урсгал усаар сайтар угаасны дараа халдваргүйжүүлэх уусмал, бактерцидны туяа болон зориулалтын индикатор тест бүхий ариутгалын тоног төхөөрөмжөөр зааврын дагуу ариутгаж тухай бүр тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.
- 9.8 Хурц ир бүхий багажийг 70%-н этилийн спиртээр норгосон хөвөнгөөр 15 минутын давтамжтай арчиж цэвэрлэнэ.
- 9.9 Үйлчилгээний өрөө тасалгаанд 7 хоногт 1 удаа их цэвэрлэгээ, өдөрт 2-с доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийж, ажлын цаг дууссны дараа халдтаргүйтгэлийг бодис уусмалаар тоног төхөөрөмж, хана, шал, тавилга, хаалгыг цэвэрлэж халдваргүйжүүлнэ.

## **10, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛД ТАВИХ ШААРДЛАГА**

Шивээсний үйлчилгээний байгууллагад ажиллагсад нь тухайн чиглэлээр сургалтанд хамрагдаж, эрх бүхий байгууллагаас олгосон мэргэжлийн диплом, мэргэшсэн түвшний чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн зэргийн үнэмлэх, дунд болон дээд мэргэжлийн дипломтой байна.

- 10.1 Ажиллагсад нь улиралд 1 удаа эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байна.
- 10.2 Гоёлын гоо заслын үйлчилгээний ажиллагсад нь үйлчилгээний онцлогт тохирсон ажлын хувцас, өөрийн нэр бүхий энгэрийн тэмдэгтэй байна.

- 10.3 Үйлчилгээний онцлог нөхцөлд тохирсон эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шаардлага хангасан хувцас, хэрэглэлтэй байна.
- 10.4 Шивээсчин нь тухайн байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулж бусад холбогдох гэрээ дотоод журмыг мөрдөж ажиллана.
- 10.5 Шивээсчин нь байнга өөрийгөө хөгжүүлж ур чадвараа ахиулах үүднээс 2 жилд 1 удаа уралдаан тэмцээн тэмцээнд оролцох, жилд нэг удаа сургалт семнарт оролцох, сургалт семнарт хамрагдан \оноо цуглуулах\ мэргэжлийн зэргээ ахиулах Үүнд:
- Шинэ дэвшилтэт техник технологийн
  - Мэргэжлийн ур чадварын
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
  - Харилцаа, хандлага, ёс зүй, үйлчилгээний соёл
  - Эрүүл ахуйн дадлагын зохистой дадлын сургалт
- 10.6 Шивээсчин үйлчилгээний чиглэлээр сургалтанд хамрагдан мэдлэг,мэдээлэлтэй болох, ур чадвар эзэмших, ажилласан жил, тэмцээн уралдааны амжилт зэрэг үзүүлэлтүүдээр зэрэглэл, түвшинг тогтоож урамшуулах.

## 12, ШИВЭЭСЧИН МЭРЭГЖЛИЙН ЗЭРЭГ, МЭРГЭШЛИЙН ТҮВШИН

- 12.1 Шивээсчний мэргэжлийн зэрэг, мэргэшлийн түвшин нь ур чадвараас хамаарч олгогдоно.
- 12.2 Шивээсчиний ур чадварыг холбогдох төрийн байгууллага, ХНХЯ, МБСҮ,МАЗТ болон Мэргэжлийн зөвлөл магадлан дүгнэж, зэрэг, түвшинг тогтоон гэрчилгээ батламжийг олгоно.
- 12.3 Мэргэжлийн боловсрол болон ур чадварыг шалгаж мэргэжлийн зэргийг баталгаажуулсан мэргэжлийн холбоодын баримт тодорхойлолтыг үндэслэн ахуй үйлчилгээний ажилтны мэдээлэлийг улсын мэдээлэлийн санд оруулна.
- 12.4 Шивээсчин мэргэжлийн зэрэг, түвшинг үнэлэхдээ тухайн хувь хүний мэргэшсэн мэргэжил, ур чадвар, гаргасан амжилт, тухайн салбарт ажилласан хугацаа зэргийг тооцоно.
- 12.5 Шивээсчин мэргэжлийн зэрэг олгох ерөнхий мэдээллийг 'Б' хавсралтанд заасны дагуу олгоно.

### А. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛД ТАВИХ ШААРДЛАГА

| Хаяг              | Зэрэглэл                             | Дээд зэрэглэл               | 1-р зэрэглэл | 2-р Зэрэглэл |
|-------------------|--------------------------------------|-----------------------------|--------------|--------------|
|                   |                                      | Эмблем бүхий гэрэлтүүлэгтэй | +            | +/-          |
|                   | Энгийн                               | -                           | -            | +            |
| Орох үүдний хэсэг | Ажиллах цагийн хуваарь               | +                           | +            | +            |
|                   | Довжоо тавцан хальтрахаас хамгаалсан | +                           | +            | +            |
|                   | Машины зогсоол                       | +/-                         | +/-          | +/-          |
|                   | Хогийн сав                           | +                           | +            | +            |
|                   | Хаалганы халаагуур \ калорифер \     | +                           | +/-          | +/-          |
|                   | Гутал цэвэрлэгч дэвсгэр              | +                           | +            | +            |
|                   | Утас                                 | +/-                         | -/+          | +/-          |
| Хүлээлгийн өрөө   | Зөөлөн тавилга                       | +                           | +            | +/-          |
|                   | Сандал                               | +                           | +            | +            |
|                   | Ширээ \сонин, сэтгүүл\               | +                           | +            | +            |
|                   | ТВ                                   | +                           | +            | +/-          |
|                   | Хөгжим                               | +                           | +/-          | +/-          |
|                   | Хогийн сав                           | +                           | +            | +            |
|                   | Хувцасны өлгүүр                      | +                           | +            | +            |

|                     |   |     |     |     |
|---------------------|---|-----|-----|-----|
|                     | Худалдааны лангуу   | +   | +/- | +/- |
|                     | Зэрэглэлийн гэрчилгээ   | +   | +   | +   |
|                     | Үйлчилгээний нийтлэг журам  | +   | +   | +   |
|                     | Дотоод журам  | +   | +   | +   |
|                     | Технологийн заавар  | +   | +   | +   |
|                     | Үнийн жишиг   | +   | +   | +   |
|                     | Гоо заслын загваруудын цомог  | +   | +   | +   |
|                     | Холбогдох сэтгүүл, сонин  | +   | +   | +   |
|                     | Мэргжлийн зөвлөмж   | +   | +   | +   |
|                     | Гутлын шүүгээ   | +   | +   | +   |
| Ариун цэврийн өрөө  | ОО өрөө   | +   | +/- | +/- |
|                     | Гарын угаагуур  | +   | +   | +/- |
|                     | Гар хатаагч   | +   | +   | +   |
|                     | Толь  | +   | +   | +   |
|                     | Саван ариутгалын бодис  | +   | +   | +   |
| Үйлчилгээний танхим | Хумс заслын үйлчилгээний өрөө,  | +/- | +/- | +/- |
|                     | Гоёлын шивээс хийх өрөө   | +   | +   | +   |
|                     | Биеийн шивээс хийх өрөө   | +   | +/- | +/- |
|                     | Вакс хийх өрөө  | +/- | +/- | +/- |
|                     | Нүүр будалтын өрөө буюу хэсэг   | +/- | +/- | +/- |
|                     | Гоо заслын өрөө   | +/- | +/- | +/- |
|                     | сормуус хийх өрөө   | +/- | +/- | +/- |
|                     | Гэрэлтүүлэгтэй нүүр будалтын ширээ толь сандал                            | +/- | +/- | +/- |
|                     | Багаж хэрэгсэл бүтээгдэхүүн, цагаан хэрэглэлийн шүүгээ, тавиур, тэргэнцэр | +   | +   | +   |
|                     | Зориулалтын ор  | +   | +   | +   |
|                     | Зориулалтын сандал  | +   | +   | +   |
| Халаалт             | Төвлөрсөн   | +   | +   | +/- |
|                     | Ердийн  | -   | -   | +/- |
| Усан хангамж        | Төвлөрсөн   | +   | +   | +/- |
|                     | Зөөврийн  | -   | -   | +/- |
| Ага арЖ уул         | Ердийн  | +   | +   | +   |
|                     | Зохиомол  | +   | +   | +/- |
| Гэрэлтү үлэг        | Байгалийн   | +   | +   | +   |
|                     | Таазны \зохиомол\   | +   | +   | +   |
|                     | Зөөврийн \зохиомол\   | +   | +   | +   |
| Шал                 | Хулдаас   | +/- | +/- | +/- |
|                     | Паркет  | +/- | +/- | +/- |
|                     | Мод   | -/+ | +/- | +/- |
|                     | Плита   | +/- | +/- | +/- |
|                     | Гантиг  | +/- | +/- | +/- |
|                     | Дэвсгэр дроз, хивс  | +/- | +/- | +/- |
|                     | Ажилчдын хувцасны өрөө, хэсэг   | +   | +   | -/+ |
|                     | Ажилчдын ариун цэврийн өрөө   | +   | +/- | -/+ |

|  |                                  |   |     |     |
|--|----------------------------------|---|-----|-----|
|  | Ажилчдад зориулсан шүршүүр       | + | +/- | +/- |
|  | Ажилчдын амралтын өрөө, хэсэг    | + | +/- | +/- |
|  | Материалын агуулах шүүгээ, хэсэг | + | +/- | +/- |
|  | Багаж ариутгалын өрөө, хэсэг     | + | +/- | +/- |

### “Б” ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

|                      | Зэрэглэл                           | Дээд зэрэглэл | 1- зэрэглэл | 2- зэрэглэл |
|----------------------|------------------------------------|---------------|-------------|-------------|
| Гоо засалч шивээсчин | Мастер 6-р түвшин                  | +/-           | +/-         | +,-         |
|                      | 1-р зэрэг 5-р түвшин               | +/-           | +/-         | +/-         |
|                      | 2-р зэрэг 4-р түвшин               | +/-           | +/-         | +/-         |
|                      | 3-р зэрэг 3-р түвшин               | -             | +/-         | +/-         |
|                      | 1, 2-түвшин                        | +/-           | +/-         | +/-         |
|                      | Үйлчилгээний менежер <b>угтагч</b> | +             | +/-         | +,-         |

#### Тайлбар:

Шивээсчны мэргэжлийн индекс байхгүй учраас гоо засалчын мэргэжлийн индексээр мэргэжлийн зэрэг түвшинг тогтооно.

#### ”В” Багж хэрэгсэл, тоног төхөөрөмж

|    | Зэрэглэл                     | Дээд зэрэглэл | 1-зэрэглэл | 2-зэрэглэл |
|----|------------------------------|---------------|------------|------------|
| 1  | Кварц аппарат \өрөөний\      | +             | +          | +          |
| 2  | Агаар чийгшүүлэгч аппарат    | +             | +          | +          |
| 3  | Ариутгалын аппарат           | +             | +          | +          |
| 4  | Томруулагч шил               | +/-           | +/-        | +/-        |
| 5  | Арьс тодорхойлогч аппарат    | +             | +          | +          |
| 7  | Угаалгын машин               | +             | +          | +          |
| 8  | Компютер                     | +             | +          | +/-        |
| 9  | Хөргөгч                      | +             | +/-        | +/-        |
| 10 | Тоос сорогч                  | +             | +          | +          |
| 11 | Нэг удаагийн даавуу хэрэглээ | +             | +          | +          |
| 12 | Хөвөн даавуун алчуур         | +             | +          | +          |
| 13 | Хөнжил орны тоогоор          | +             | +          | +          |



|   |   |     |     |     |
|---|---|-----|-----|-----|
| 14  | Ажилчдын хувцас<br>Онцлох тэмдэг бүхий нэг загварын хувцас, энгэрийн тэмдэг \халад, малгай, шаахай, нэг удаагийн хэрэглээний бээлий амны хаалт\ | +   | +   | +   |
| Шивээсний өрөө                                  | Үйлчлүүлэгчдэд зориулсан халад, хормогч малгай  | +   | +   | +   |
|   | Шивээсний дижитал аппарат   | +   | +   | +/- |
|   | Механик шивээсний аппарат   | +   | +   | +/- |
|   | Шивээсний зүү \ нэг удаагийн \  | +   | +   | +   |
|   | Шивээсний будагний сав нэг удаагийн   | +   | +   | +   |
|   | Шивээсний аппаратны хошуу нэг удаагийн  | +   | +   | +   |
|   | Туслах багаж хэрэгсэл   | +   | +   | +   |
|   | Багаж хэрэгсэл тавих тавцан\ лотошка\   | +   | +   | +   |
|   | Будаг найруулах аяга, савх  | +   | +   | +   |
|   | Ариун материал  | +   | +   | +   |
|   | Арьсны хэв шинж тодорхойлох аппарат, индикатор  | +   | +   | +   |
|   | Шивээсны ор   | +   | +   | +   |
|   | Шивээсний сандал  | +   | +   | +   |
| Гоо заслын өрөө                                 |   |     |     |     |
|   | Гоо заслын зориулалтын сандал буюу ор   | +/- | +/- | +/- |
|   | Сандал орны тоогоор   | +/- | +   | +   |
|   | Орны тоогоор тавиур   | +/- | +   | +   |
|   | Нэмэлт зөөврийн гэрэл   | +/- | +   | +   |
|   | Томруулдаг шил  | +/- | +/- | +/- |
|   | Хөмсөг засах багаж  | +   | +   | +   |
|   | Багаж хэрэслэлийн ариутгалын аппарат \ цахилгаан шүүгээ, буцалгаж ариутгагч гэх мэт\  | +   | +   | +   |
| Гоо сайхны бүтээгдэхүүний тавиур                | +   | +   | +   |     |
| Толгойн бүх төрлийн боолтууд төрөл бүрийн багаж | +   | +   | +   |     |

**Тайлбар; + Заавал байх шаардлагатай**  
**+/- Заавал байх шаардлагагүй**  
**- Шаардлагагүй**